



САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 2013 оны II сар


ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: ДНБ, УЛСЫН ТӨСӨВ, ГАДААД ХУДАЛДАА, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ

Эдийн засгийн өсөлт 12.3%

(2012 он урьдчилсан гүйцэтгэлээр)


ДНБ 2012 оны эцэст оны үнээр 13.9 их наяд төгрөгт (10.0 тэрбум ам.доллар) хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25.8%, харин 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5.4 их наяд төгрөг (3.9 тэрбум ам.доллар) болж, өнгөрсөн оны мөн үеэс 12.3% тус тус өссөн байна.

ДНБ-ий улирлын бодит өсөлт (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 10.6% хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.0 дахин бага үзүүлэлт юм.



Төсвийн тэнцэл 83.8 тэрбум төгрөгийн ашигтай


Улсын нэгдсэн төсвийн орлого 2013 оны эхний 2 сарын байдлаар 699, зарлага 615 тэрбум төгрөг болж төсвийн тэнцэл 83.8 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад орлого 3.6% өсч, зардал 9.8% буурсан байна. Орлогын өсөлтөд ААНОАТ 19.5%, ХАОАТ 53.7%, НДШ 35.2%, ОАТ 35.9%, НӨАТ 6.6%, тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бол зарлагын бууралтад тагаас ба шилжүүлэг 11.6% мөн дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгийн зардал 79.3% буурсан нь нөлөөлжээ.



Гадаад худалдааны алдагдал 0.3 тэрбум ам.доллар

Нийт барааны эргэлт 2013 оны эхний 2 сарын байдлаар 1317.3 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1% буурсан байна. Экспорт 3.9% мөн импорт 13.6% буурснаас гадаад худалдааны алдагдал 305.1 сая ам.доллар болжээ.

Нүүрсний экспорт өмнөх оны мөн үеэс 35%, жоншны хүдэр ба баяжмал 28% буурчээ. Импортын бууралтад суудлын болон ачааны автомашин 39%, бульдозерь авто хусуур, индүүдэгч, тэгшлэгч, эксковатор 63% буурсан нь нөлөөлжээ.



Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтвортой хэвээр байна

Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш энэ сард 1,394 байлаа. Энэ нь өмнөх сарын ханшаас 0.1% харин өнгөрсөн оны мөн үеэс 4% суларсан үзүүлэлт юм. Гадаад валютын нийт албан нөөц 3992.7 сая ам.доллар болсон нь өнгөрсөн сарынхаас 1.8% буурч, өмнөх оны мөн үеэс 65% өссөн үзүүлэлт болжээ.



Инфляцын түвшин 11.3% болов

Улсын хэмжээнд тооцсон жилийн инфляцийн түвшин 11.3% байна. 2012 оны эхнээс тухайн оны 2 дугаар сар хүртэл инфляци 5.4% байсан ба энэ оны эхнээс 2-р сарын эцсийн байдлаар 2.8% байгаа нь түвшин буурсныг харуулж байна. Инфляци өмнөх сарынхаас 1% өссөн нь өрхийн хэрэглээний гол бараа бүтээгдэхүүнүүдийн үнэ өссөнтэй холбоотой. Ихэнхи аймгуудад махны үнэ 13%, төмс хүнсний ногооны үнэ 17%, сүүний үнэ 6% өссөн нь хүнсний бараа бүтээгдэхүүний бүлгийн дундаж үнийг 3% өсгөж улмаар ерөнхий индексийн өсөлтөд нөлөөлжээ.




Эх сурвалж: УСХ, МБ

САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 0.7 их наяд төгрөг


M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 16% нэмэгдэж, өнгөрсөн сарынхаас 1.4% буурч 7.2 их наяд төгрөг (5.2 тэрбум ам.доллар) болжээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 0.3% нэмэгдэж, өмнөх сарынхаас 9% буурч 676 тэрбум төгрөг болсон нь нийт мөнгөний 9.3%-ийг эзэлж байна.



Хадгаламж өссөн хэвээр


Хадгаламжийн хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад 24%, өмнөх сарынхаас 0.4% өсөж 5 их наяд төгрөг (3.6 тэрбум ам.доллар) байна.

Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 23%, валютынх 26%, өмнөх сарынхтай харьцуулахад төгрөгийн хадгаламж 2.6% өсөж, валютын хадгаламж 5.6% буурсан байна. Төгрөгийн ханшны тогтвортой байдал төгрөгийн хадгаламжид эерэгээр нөлөөлж байгаа.



Чанаргүй зээлийн эзлэх хувь хэвээр байна

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сарынхаас 0.4%, өнгөрсөн оны мөн үеэс 25.6% тус тус нэмэгдэж, 7,168 тэрбум төгрөг (5.1 тэрбум ам.доллар) боллоо. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сарынхаас 0.6%, өнгөрсөн оныхоос 5.4% буурч, нийт зээлд эзлэх хувь 4.3% хэвээр байна. Банкуудын зээлийн хүү (жилийн, жигнэсэн дундаж) жилийн өмнөхөөс төгрөгийнх 0.7 өсөж, валютынх 0.9 нэгжээр буурч жилийн хүү төгрөгийнх 19.1%, валютынх 13.1% болжээ.



Эх сурвалж: YCX, МБ

Сарын онцлох үйл явдал

- > Монголбанк бодлогын хүүнээс +/-2 нэгж хувь өргөнтөй байх хүүний коридор шинээр нэвтрүүлэхээр шийдвэрлэв.
- > Бондын хөрөнгөөр аймгуудын төвийг нийслэлтэй холбох авто зам, нийслэлд дөрвөн замын уулзвар болон хурдны зам, Тавантолгойн уурхайг түшиглэсэн эрчим хүчний цахилгаан станц, Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэлх төмөр замын ажил гэсэн 4 төслийг санхүүжүүлэх зөвлөмж гаргалаа.
- > Монгол Улс Оюутолгой ХХК дахь шийдвэр гаргах мөн ашиг хүртэх хувь хэмжээг ихэсгэхийг шаардлаа.
- > Чингис бондын хүүгийн түвшин 41 нэгжээр өсөж 5.85% хүрлээ.

Хураангуй

2013 оны 2 дугаар сард Улсын нэгдсэн төсөв эерэг үзүүлэлттэй хэвээр гарлаа. Сар шинийн баяр болж бараа бүтээгдэхүүний үнэ өндөр байсан хэдий ч инфляци буурсан үзүүлэлттэй байна. Төсвийн зардал харьцангуй бага хэвээр байгаа. Дизель түлшний импортын хилийн үнэ 26%, дотоодын зах зээлийн бөөний үнэ 28% өссөн бол жижиглэнгийн үнэ 6% л нэмэгджээ. Олон улсын хөрөнгийн зах зээлээс босгосон 1.5 тэрбум ам.доллар Монголбанкны дансанд шилжиж орж ирснээр валютын нөөц нэмэгдэж ханшийг тогтворжуулсны зэрэгцээ төв банк бодлогын хүүгээ бууруулах шийдвэр гаргасан. Эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор арилжааны банкуудад эхний ээлжинд 400 тэрбум төгрөгийг жилийн 7% хүүтэйгээр байршуулан төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж байгаа. Энэхүү гадаад валютаар баталгаажсан өртөг багатай төгрөгийн эх үүсвэр нь инфляцийг нэмэгдүүлэхгүй хэмээн мэргэжилтнүүд үзэж байна. Гэвч нөгөө талаас, Чингис бонд болон Хөгжлийн банкны үнэт цаасны үнэ цэнэ нь буурчээ. Олон улсын судлаачдын үзэж байгаагаар бондын хүүгийн өсөлт нь ерөнхийлөгчийн сонгууль, өнөөгийн улс төрийн тодорхой бус байдлаас үүдэж хөрөнгө оруулагчдын итгэл суларч буйг илтгэж байна. Гэвч бондоо ашигтайгаар байршуулсан тул хүүгийн зардал нь алдагдал болохгүй хэмээн албаны хүмүүс үзэж байна. 2009 онд байгуулсан Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг дахин шинэчлэнэ хэмээн 2013 оны Улсын төсвийн орлогыг төсөвлөсөн билээ. Тиймээс ч Засгийн газар хатуу шаардлага тавьж байна. Энэхүү дахин гэрээний нэмэлт орлогоос гадна Оюутолгой мөн Тавантолгойгоос олборлосон эрдэс баялагийг экспортлож ашигт малтмалын орлогыг 62% өснө хэмээн тооцсон байгаа. Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх уул уурхайн олборлолт 60% өсөж чадах эсэхийг одоогоор таамаглахад хэцүү байна.